


ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

THE NEED AND REQUIREMENTS TO ENSURE GENDER EQUALITY AT THE DECISION-MAKING LEVEL OF JUDICIAL DECISION EXECUTION ORGANIZATIONS



Б.Анун

*Дотоод хэргийн их сургуулийн,
Удирдлагын академийн магистрант, дэслэгч*

Товч агуулга: Монгол Улс дахь жендэрийн тэгш байдал ялангуяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, нөлөөлж буй хүчин зүйлсүүдийг тодорхойлж эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Эмэгтэйчүүд уян зөөлөн, энэрэнгүй зан чанар, байгалиасаа бусдыг хайрлах, бусдын төлөө өөрийгөө зориулдаг өмгөөлөгч, багш, эмч гэх мэт мэргэжлүүдийг их сонгож ар гэр, гэр бүлийн амьдралдаа үүрэг роль ихтэй оролцсоор хууль хүчний байгууллагуудаас зайгаа авч байна.

Энэхүү илтгэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр шаргах түвшин дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого хэрэгжилтийг судалж тодорхойлон, шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагчдын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг гаргахыг зорьлоо.

Түлхүүр үг: Жендэр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Жендэрийн тэгш байдал, Эмэгтэйчүүдийн оролцоо,

Keywords: Gender, Judiciary, Gender Equality, Women's Participation,

Оршил

Жендэрийн сургаалийн үүсэл нь анх XX зууны эхэн үеэс эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг хамгаалахаар гарч ирсэн ойлголт байсан ба аажимдаа нийгэм, соёлын бүхий л салбарыг хамруулсан жендэр судлал болтлоо хөгжсөн

байна¹. Жендэр гэдэг үг нь англи хэлэнд “gender²”, орос хэлэнд “гендэр³” буюу “хүйс” гэх латин үгнээс гаралтай бөгөөд жендэр судлал нь гэр бүл, жлс төр, нийгэм, нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл хандлагыг судалдаг шинжлэх ухаан юм. Жендэр гэж зөвхөн эрэгтэй эмэгтэй гэх хоёр хүйсийн тухай ойлголт биш. Жендэрийн агуулга нь нийгэм, соёл бүрт харилцан адилгүй бөгөөд цаг хугацаанд хувиран өөрчлөгдөж байдгаараа биологийн шинжлэх ухаанаар тодорхойлогдсон хүйс хэмээх нэр томъёоноос ялгаатай.

Монгол Улс эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш, шударга хандах үзэл санааг 1924, 1940, 1960, 1992 онуудад баталсан 4 удаагийн үндсэн хуулиндаа тусгаж, холбогдох олон улсын гэрээ конвенциудад нэгдэн орсон⁴ бөгөөд жендэр судлал нь 1970-аад оны үеэс үүсч, жендэр ба хөгжил гэсэн хүн төрөлхтний нийгмийн дэвшлийн шинэ цогц үзэлтэй хамаатайгаар ихээхэн хурдацтай хөгжиж байна. Жендэр эрх тэгш байдал нь бүхий л салбарт чухал нөлөө үзүүлдэг бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд ч энэхүү тэгш эрх хангагдсанаар эерэг нөлөө үзүүлэх юм.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хэрэгжилтийн талаар судлахын өмнө шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголтыг товч авч үзье.

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” хэрэгжүүлнэ⁵. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно. Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хүний эрх, эрх чөлөө, мэргэжил, нийгмийн гарал, үзэл бодол, боловсролоор үл ялгаварлан аливаа хөгжлийн үйл явцад оролцож үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдсан байдал юм. Шүүхийн

¹ <https://medium.com/@awaremongolia/>

² Гендер-Википедиа_(wikipedia.org) (хандсан хугацаа 2024.11.02)

³ Что_такое_гендэр? Простыми_словами_о_сложном_(intrigue.dating) (хандсан хугацаа 2024.11.02)

⁴ Гансүх. Л. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь жендэрийн тэгш эрхийг хангах зарим асуудал. Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэнд тулгамдсан асуудал. Уб., 2015. 145 дахь тал

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24

шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага болон жендэрийн тэгш байдлын тухай ойлголт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүний эрх, эрх чөлөө, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь үл ялгаварлана гэх ойлголтоор огтлолцож байна. Гэхдээ жендэрийн тэгш байдал нь зөвхөн эрэгтэй эсхүл эмэгтэй хүмүүсийн хүйсийн тэнцүү байдлын тухай ойлголт биш. Харин тодорхой нөхцөлд цөөнх болж буй хүмүүсийн ижил тэгш эрхийн тухай ойлголт.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт эрэгтэй, эмэгтэй алба хаагчдын хүйсийн харьцаа 2024 оны байдлаар **62.8:37.2** хувьтай байгаа нь хууль сахиулах салбар дахь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр хувьтай байна. Гэхдээ шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй нийт алба хаагчдын ердөө **14.8** хувь эмэгтэй алба хаагчид байна. Өнгөрсөн хугацаанд удирдлагын шийдвэр гаргах түвшинд ажиллаж байсан бүрэлдэхүүнийг хэлбэрийн хувьд авч үзвэл нийгмийн дунджаас дээд давхаргын, 50 гаруй насны, эсхүл эрэгтэйчүүд зонхилж¹ байсан судалгаа байдаг. Гэхдээ цаг үе, нийгэм өөрчлөгдөхийн хэрээр эмэгтэйчүүд боловсрол эзэмшиж чадавхжаар байна. Тэгш байх ижил тэнцүү гэх ойлголт нь 50:50 хувь байх ба шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх оролцоог хангах нь зүйтэй.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.3-т “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх² гэж заасан байна. Төрийн тусгай алба нь үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг, биеийн болон сэтгэлзүйн байнгын бэлтгэл шаардсан, тушаалаар үүрэг гүйцэтгэдэг онцлогтой юм.³ Дээрх хуулийн заалтаас харахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын хүйсийн харьцааг хуульчлан заагаагүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд тодорхой хууль, дүрэм журамд хүйсийн харьцааг хуульчлах шаардлагатай байж болох юм. Тухайлбал:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 232.2-т Хоригдлын биед хийх үзлэг, нэгжлэгийг хоригдолтой ижил хүйсийн алба хаагч гүйцэтгэнэ гэж заасан байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь тэр

¹ Гантуул. А. Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал, Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл. №4, 2018.


² Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УБ., 2011 он Төрийн мэдээлэл эмхэтгэл №08

³ Хүний эрхийн үндэсний комисс 22 дах илтгэл

дундаа хорих байгууллагын алба хаагчид нь Монгол Улсын хууль, журам зөрчин хариуцлага хүлээж буй этгээдүүдтэй өдөр тутам харьцах бөгөөд ажил үүргээ хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүний зан ааш, сэтгэл зүй, гадаад байдал, бие организм, сэтгэлгээ зэрэг олон онцлог талууд нь маш их нөлөөлдөг¹. Мөн эмэгтэй алба хаагч ажиллахад тохиромжтой ажлын байр байсаар байна. Жишээ нь:

Шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, бичиг хэргийн ажилтан, тоо бүртгэлийн ажилтан зэрэг албан тушаалд ажиллахад эмэгтэй хүний онцлог шинж, нарийн мэдрэмж, уян зөөлөн байдал, ярилцах, ойлголцох чадвар шаардагддаг байна. Харин манай байгууллагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагч ажиллаж оролцох шаардлага байгаа тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 500 алба хаагчдаас санал асуулга судалгаа авахад:

График 1. Судалгаанд оролцогчдын ангилал (хүйс)



Судалгаанд оролцогчдын 54% буюу 270 эмэгтэй, 46% буюу 230 нь эрэгтэй алба хаагчид байна. Дээрх судалгаанд оролцогчдын 117 алба хаагч удирдах албан тушаалд 383 алба хаагч гүйцэтгэх албан тушаалд ажилладаг.

Нийт судалгаанд оролцсон алба хаагчдаас “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагч ажиллаж оролцох” шаардлагуудыг нэрлэнэ үү ? гэхэд дараах шаардлагуудыг дурдав. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй нийт эмэгтэй алба хаагчдын дуу хоолой болж тэдний эрхийг хамгаална.
- Эмэгтэй алба хаагчдын ажиллах нөхцөл, хэрэгцээт шаардлагыг ижил хүйсийн алба хаагч ойлгож сонсож тусална


¹ Оюунтай. Э. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал. “Хууль Сахиулахуйн Удирдлага” онол, арга зүйн сэтгүүл. -Уб., №3, 2021. 139 дэх тал

- Эмэгтэй алба хаагчдад тулгамдаж буй асуудлыг шийдвэр гаргах түвшинд хэлэлцэж тодорхой шийдэлд хүргэнэ.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх, гэр бүл, ажил гэх мэт нийгмийн олон талт харилцааг зохицуулахад эерэг үр нөлөө үзүүлнэ.
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагч байх нь нийтийн эрх ашгийг чухалчилж, хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй, шударга байдлыг бий болгоно.
- Аливаа хууль, дүрэм журам, бодлого боловсруулахад аль ч хүйсийн тэгш эрхийг хангана.
- Алба хаагчдын гэр бүлийн байдлыг дэмжиж, хувь хүний хөгжилд анхаарах саналуудыг бий болгоно.
- Цалин хөлс, албан тушаал, ажил, мэргэжил, хангалт үйлчилгээ гэх мэт бүхий л үйл ажиллагаанд аль ч хүйсийн алба хаагчид ижил тэгш оролцож, үр шимийг тэнцүү хүртэнэ.
- Эмэгтэй алба хаагчдыг чадваржуулах тэдний оролцоог хангах олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.
- Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй манлайлагч эмэгтэй алба хаагчдаас урам авч ажиллах идэвх нэмэгдэнэ.

Дээрх саналуудаас харахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшинд жэндэрийн тэгш байдлыг хангах шаардлага байна. Уг шаардлагын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ямар ямар бодлогын баримт бичгийг боловсруулан ажилладаг вэ?

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он), Хууль сахиулах жендэрийн нэгдсэн бодлогоуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

График 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дагаж мөрддөг хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн судалгаа



Дээрх судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан алба хаагчдын 58,4% хувь буюу 292 алба хаагч “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө”-г, 20,6% буюу 103 алба хаагч “Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого”-г дагаж мөрддөг хэмээн дийлэнх нь хариулсан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он) нь Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг дэмжиж, ирэх арван жилд төр, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хамтран хэрэгжүүлэх салбар дундын стратеги төлөвлөгөө юм. Энэхүү стратеги төлөвлөгөө нь нийт 5 зорилт 242 үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого (2018-2021) нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Хууль зүйн салбарын нээлттэй бодлого, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд байгууллага нэгжийн зорилго, үйл ажиллагаа, тогтолцоо, бүтэц, хүний болон санхүүгийн нөөцийн хуваарилалтаар дамжин, удирдлагын дэмжлэг, хамт олны хүчин чармайлт, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хэрэгжинэ. Энэхүү бодлогын зорилго¹ нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон түүний харъяа хууль сахиулах байгууллагын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт

¹ <https://mojha.gov.mn/wp-content/uploads>

үнэлгээнд нэвтрүүлэх замаар байгууллагын бүх түвшинд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэхэд оршино. Жендэрийн нэгдсэн бодлогоын үйл ажиллагааны төлөвлөгөө нь 4 зорилт 12 үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй.

Зураг 4. Хууль сахиулах байгууллага дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бологын хэрэгжүүлэх бодлогын судалгаа



Судалгаанаас харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага жендэрийн тэгш эрхийг хангах бодлого хэрэгжүүлэхдээ журмаар зохицуулдаг гэж хариулсан алба хаагчид 10% буюу хамгийн бага байгаа бол дүрэмд тусгасан болон жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан гэх хариулт өгсөн алба хаагчид 11%-23% байгууллагын жендэрийн дэд зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан гэх сонголтыг 66% буюу хамгийн их алба хаагч сонгосон байна. Үүнээс үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага жендэрийн тэгш эрхийг хангах бодлого хэрэгжүүлэхдээ тодорхой хууль, бодлогын хүрээнд дотооддоо тодорхой дүрэм, журам боловсруулж жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаас гадна байгууллагын жендэрийн дэд зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Хууль сахиулах салбарын байгууллагууд жендэрийн дэд зөвлөл байгуулан байгууллагынхаа жендэрийн эрх тэгш байдлыг хангахад нөлөө бүхий олон төрлийн арга хэмжээ зохион байгуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жендэрийн дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга х/ч Ч.Ш-тэй фокус ярилцлага хийхэд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар ШШГБ-ын Жендэрийн асуудал хариуцсан дэд зөвлөл 9 гишүүнтэй байхаар шинэчлэн баталсан. Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллагын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021-2024 онуудад 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус боловсруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай сургалтыг 2020 онд 6 удаа, 2021 онд 2 удаа, 2022 онд 6 удаа, 2023 онд 3 удаа тус тус нийт алба хаагчдад зохион байгуулсан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагчдын тоог нэмэгдүүлэх хүрээнд эмэгтэй алба хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулж дэмжсээр байгаа гэв.

Дүгнэлт, санал

Хүний амьдралын бүхий л салбарт жендэр эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ оршсоор байна. Төрийн албанд ч тэр төрийн бус байгууллага ч тэр гэр бүлийн харилцаанаас улс төрийн харилцаа хүртэл. Жендэрийн эрх тэгш байдал хангагдсанаар шударга байдал нийгэмд тогтоож ялгаварлан гадуурхах үзлээс ангид байж аливаа үйл ажиллагаа илүү бүтээмж сайтай байх болно. Бүх хүн тэгш эрхтэй учраас хэн ч аль ч салбарт гадна төрх, хүйс, гарал үүсэл гэх мэт шалтгаанаар гадуурхагдаж үл болно. Жендэр бол ялгаварлан гадуурхалтыг үл бий болгож эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүмүүст ижил тэгш боломж олгон бүхий л харилцаанд үүрэг, хүлээх хариуцлага, тэднийг нийгэмд эзлэх байр суурийн уламжлагдан тогтсон түүхэн явцад өөрчлөгддөг ойлголт үзэл хандлага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлагуудыг судалж дараах дүгнэлт, саналыг дэвшүүллээ.

Нэгдүгээрт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт эрэгтэй, эмэгтэй алба хаагчдын хүйсийн харьцаа 2024 оны байдлаар **62.8:37.2** хувьтай байгаа нь хууль сахиулах салбар дахь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр хувьтай байгаа хэдий ч шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй нийт алба хаагчдын ердөө **14.8** хувь эмэгтэй алба хаагчид байна. Тэгш байх ижил тэнцүү гэх ойлголт нь 50:50 хувь байх ба шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх оролцоог хангах нь зүйтэй.

Хоёрдугаарт. Хууль сахиулах байгууллагуудын ажилчин, алба хаагчдад жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах алба хаагчдын дунд жендэрийг хүйсийн тэнцвэрт байдалтай ижил ойлгодог хэвшмэл ойлголтыг арилгах.

Гуравдугаарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэй алба хаагч ажиллаж оролцох нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй нийт эмэгтэй алба хаагчдын дуу хоолой болж тэдний эрхийг хамгаалах, эмэгтэй алба хаагчдад тулгамдаж буй асуудлыг

шийдвэр гаргах түвшинд хэлэлцэж тодорхой шийдэлд хүргэх, нийтийн эрх ашгийг чухалчилж, хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй, шударга байдлыг бий болгох, аливаа хууль, дүрэм журам, бодлого боловсруулахад аль ч хүйсийн тэгш эрхийг хангах, алба хаагчдын гэр бүлийн байдлыг дэмжиж, хувь хүний хөгжилд анхаарах саналуудыг бий болгох, цалин хөлс, албан тушаал, ажил, мэргэжил, хангалт үйлчилгээ гэх мэт бүхий л үйл ажиллагаанд аль ч хүйсийн алба хаагчид ижил тэгш оролцож, үр шимийг тэнцүү хүртэх, эмэгтэй алба хаагчдыг чадваржуулах тэдний оролцоог хангах олон талт үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт хэрэгцээ шаардлагууд байгаа учир шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх.

Дөрөвдүгээрт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага жендэрийн тэгш эрхийг хангах бодлого хэрэгжүүлэхдээ тодорхой хууль, бодлогын хүрээнд дотооддоо тодорхой дүрэм, журам боловсруулж жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаар гадна байгууллагын жендэрийн дэд зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг ихэнхдээ хэрэгжүүлдэг учир жендэрийн дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгах.

Тавдугаарт. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулинд шийдвэр гаргах түвшинд хүйсийн харьцааг 60:40 байхаар хуульчилж эмэгтэй алба хаагчдыг чадавхжуулж, дэмжих.

Эх сурвалж

Хууль тогтоомж:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УБ., 2011 он Төрийн мэдээлэл эмхэтгэл №08

Ном, бүтээл:

1. А. Гантуул. Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал, Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл. №4, 2018.

2. Л. Гансүх. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь жендэрийн тэгш эрхийг хангах зарим асуудал. Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэнд тулгамдсан асуудал. УБ., 2015.

3. Э. Оюунтай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал. “Хууль Сахиулахуйн Удирдлага” онол, арга зүйн сэтгүүл. -УБ., №3, 2021.

4. Хүний эрхийн үндэсний комисс 22 дах илтгэл

Цахим эх сурвалж:

1. <https://medium.com/@awaremongolia/>
2. Гендер-Википедиа_(wikipedia.org) (хандсан хугацаа 2024.11.02)
3. Что_такое_гендэр?_Простыми_словами_о_сложном_(intrigue.dating) (хандсан хугацаа 2024.11.02)
4. <https://mojha.gov.mn/wp-content/uploads>

---o0o---